**УЛААНБААТАР**
**ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/15 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 14 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ-ын дүрмийн 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Иргэдийн оролцоотой - Амьдрах орчныг сайжруулах жил”-ийн Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус газрын гэр хороололд амьдардаг ажилтнуудаас судалгаа авч, түүхий нүүрсний хэрэглээнээс татгалзаж утаагүй түлш болон эко хэрэглээний оновчтой шийдлийг гаргах, санал боловсруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ахлагч: | Э.Золзаяа | Үйл ажиллагаа, төлөвлөлтийн хэлтсийн Төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн |
| Гишүүд: | Б.Мөнхсүх | Засвар ашиглалтын албаны Гэрэлтүүлгийн инженер |
| | Д.Нямдарь | Шуурхай албаны Ахлах инженер |
| | Ц.Орхонбаяр хэлтсийн | Үйл ажиллагаа, төлөвлөлтийн Эдийн засагч |
| | С.Пүрэвдулам | Үйлдвэрлэлийн албаны Эдийн засагч |
| | Х.Болормаа | Авто баазын нярав |
| Нарийн бичгийн дарга: | Г.Дөлцэцэг | Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хүний нөөцийн ажилтан |

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хавсралт ёсоор батлалсугай.

3. Энэхүү тушаалын 1 дүгээр зүйлд заасан саналыг боловсруулж, 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг /Э.Золзаяа/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Ё.Батболд/-д даалгасугай.

ДАРГА Ж.ЧИНЗОРИГ

D:\TUSHAAL\ tushaal A 2018 .docx

3130000140

“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар”
ОНӨААТҮГ-ын даргын 2018 оны .04. дугаар
сарын .10. өдрийн .../... дугаар тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

1. Ажлын хэсэг доорх хоёр агуулга бүхий судалгаа хийж, төлөвлөгөө боловсруулах
   Өрхийн судалгаа: Байгууллагын ажилтнуудын гэр хороололд амьдарч буй иргэдийн тоог тодорхой болгох
   Дулаан алдагдлыг бууруулах, түлшний судалгаа: Утааг багасгах, дулаан алдагдлыг бууруулах, түүхий нүүрсний хэрэглээнээс татгалзах, дулаан алдагдал, утаагүй түлш болон эко хэрэглээний оновчтой шийдлийг гаргах
2. Судалгаанд тулгуурлан дулаан алдагдлыг бууруулах үр дүнтэй аргыг сонгох, утаагүй түлшний сонголт хийх
3. Дулаан алдагдлын үр дүнтэй бууруулах боломжуудын талаар гэр хороололд оршин суудаг ажилтнуудад таниулах сургалт хийн, сурталчилгаа явуулах
4. Байгууллагын “Иргэдийн оролцоотой – амьдрах орчныг сайжруулах жил” төлөвлөгөөний хүрээнд тусгагдсанаар жишиг тохижуулан, дулаалах 6-9 айл өрхийг сонгон удирдлагад санал болгох

-o0o-